

ТӨРИЙН ЁС СУРТАХУУНЫ ҮҮРГИЙН ТУХАЙ А.ШОПЕНГАУЭРЫН ҮЗЭЛ

Ш.Ганхуяг. МУИС. НШУС. Философийн тэнхим. дэд профессор.

Түлхүүр үг: гэрээ хэлэлцээр, хууль зүй, ёс суртахуун, олон нийтийн эрх.

Германы философич А.Шопенгауэр "Дур зоргын эрх чөлөө" (1839) номондоо: "Ард түмэн зөвхөн өөрөө өөртөө олгосон хуулиар удирдуулсан тохиолдолд газар сайгүй өөрийнх нь хүсэл зориг үйлчлэх ба үүнийг эрх чөлөө гэж нэрлэнэ" гэж бичсэн байдаг. Бүх хүмүүс, бүх үеийн философичид төрийг ийм л зарчмаар үйлчлээсэй хэмээн хүсэн хүлээж, үүнийг л төрийн цорын ганц үүрэг хэмээн тодорхойлж ирсэн.

А.Шопенгауэр өөрийнхөө үзлийг тодорхойлохын тулд И.Кантын "эршүүд императивын хуулийг" шүүмжилж: "Болж буй үйл явдлын үндэслэгээг гаргахын тулд биш, харин болох ёстой гэж [И.Кант] бодож байгаа боловч хэзээ ч болохгүй үйл явдлын хуулийг Практик философидоо тогтоох гээд байна" гэжээ. Ийнхүү ёс суртахууны үнэмлэхүй, түгээмэл, зайлшгүй, эршүүд, хэлбэрдмэл хуулийг хий хоосон агаарт өлгөж тогтоосх гэсэн аливаа оролдлогыг шүүмжилжээ.

"Хүний хувьд адгуустай адил гол үндсэн шалтгаан нь хувиа хичээх явдал буюу ахуй амьдрал, аж төрөлд татагдах явдал юм", "хэн нэгэн хүн өөрийгөө, эсвэл бүх ертөнцийг устгах хоёр сонголтын аль нэгийг шийдэх хэрэгтэй бол ихэнх хүмүүс аль талд байх вэ гэдэг нь тодорхой" гэх мэтээр А.Шопенгауэр бичсэн байдаг нь хүний жинхэнэ мөн чанар нь хувиа хичээх, өөрийгөө ямар ч аргаар хамаагүй хамгаалах явдал хэмээн тодорхойлсон хэрэг мөн. "Ихэнх хүмүүс хувиа хичээсэн, шудрага бус, харамч, хуурамч, заримдаа бүр харгис байхаас гадна оюун ухааны чадавхид нь эрхэм ариун чанар тун бага байдаг" гэснээрээ А.Шопенгауэр хүмүүсийн харилцаанд байх ёстой ёс суртахууны дээд чанарыг санал болгож, гэхдээ тэр нь хүмүүст байдаггүйд хэргийн бүх учир оршино гэж үзсэн байна.

А.Шопенгауэр: "Ариун дээд эрийг ухаалаг, тэнгэрлэг бүсгүйтэй гэрлүүлэх замаар жинхэнэ язгууртан, жинхэнэ сайн төрлийн хүмүүсийн ноёрхлыг тогтоож болно гэх нь миний утопи, миний платоны төр улс болно" гэж өөрийн хүсэл мөрөөдлийг илэрхийлсэн бөгөөд тэрээр сайн язгуурт, дээд ариун хүнийг жирийн хүнээс өөр төрөл язгуурт авч үзжээ. Өөрөөр хэлбэл, шудрага бус хүмүүст хүн ёсны ариун чанар байхгүй гэдгийг дахин дахин тодорхойлсон байна. Гэхдээ нийт хүмүүсийн чанар болсон энэхүү шудрага бус үйлдэл нь төрийн хууль эрхээр ёс суртахууны талд өөрийн эрхгүй шийдэгддэг болохыг философийн ул суурьтай онолоор батлан тодорхойлсон байдаг.

"Төр, улс төр, эрхийн тухай бодролууд" номонд А.Шопенгауэр ёс суртахуун ба хууль эрхийн харилцан хамаарлын асуудлыг хэрхэн авч үзсэнийг энэ өгүүлэлдээ хөндөн ярьжээ.

Энэхүү номонд А.Шопенгауэр хүний мөн чанарыг дараахь байдлаар тодорхойлжээ: Хүмүүс "энэ миний гар, хөл, бие эрхтэн" хэмээн бие организмээ заана, эсвэл "надад тийм ч юм хэрэгтэй, ийм ч юм

шаардлагатай" хэмээн үргэлжийн сэтгэл ханамжгүй байдлаа илэрхийлнэ. А.Шопенгауэрынхаар эцэ бол хүний жинхэнэ мөн чанар, нүүр царай юм.

Гэхдээ А.Шопенгауэрын өөр нэгэн тайлбарт, хэдийгээр хүмүүс өөрт нь тааламжтай агшин гарах бүрд шудрага бус үйлдлийг хийж, бусад хүмүүсийг хохироож байдаг боловч өөрөө бас ийм шудрага бус үйлдлийн бай болж хохирохгүйг хүн бүр бодож айж эмээж болгоомжилж байдаг. Бүх хүн шудрага бус үйлдлийг хийхгүй болчихвол бүгдээрээ аз жаргалтай болсхон гэсэн бүх нийтийн хүслийн үүднээс төрийн хэлэлцээр буюу төрийн хууль ёс үүссэн гэж А.Шопенгауэр үзсэн байна. Ийнхүү хүмүүс шудрага бус үйлдлийн бай болохгүйн тулд хууль журам, гэрээ хэлэлцээр боловсруулан гаргадаг гэсэн төрийн хууль эрхийн үүслийн шалтгааныг философи бодролоороо тэрээр тогтоожээ.

Хэрвээ хэн нэгэн хүн бусдыг эзэмдэж, өөрийнх нь хүслээс ангид үзлийг үл хүлээн зөвшөөрч, бусдыг өөрийн эрхшээлд оруулахыг хүсэх аваас өөрийнхөө хүсэл зоригийг бусдад тохоож байгаа хэрэг мөн. Ийнхүү бусдаар өөрийнхөө хүсэл зоригийг тогтоох явдал хүн төрөлхтний түүхийн бүхий л үед байсан ба үүнийг "шудрага бус явдал" гэж нэрлэж ирсэн юм. Бусдын дур хүслийг өөр дээрээ авч, бусдын дур хүсэлд захирагдах нь ямагт биеэр эдлэх зовлонгоос ялгаатай сэтгэл санааны зовлон, сэтгэлийн дотоод хямралыг үүсгэдэг гэх мэтээр хүмүүсийн дунд түгээмэл байдаг шудрага бус үйлдлийн эцсийн үр дүнд хүмүүс өөрөө өөрсөддөө зовлон хураадгийг тайлбарласан байна. Үнэндээ хүмүүсийн зовлон хямралаа өөрсдөө ашгийн хойноос хөөцөлдсөн шудрага бус үйлдлүүдээрээ бий болгож байдаг гэсэн үзлийг А.Шопенгауэр дэвшүүлжээ.

"Миний шудрага бус үйлдлийн хэмжээ нь би бусдад учруулсан зовлонгийн хэмжээг түүнээс олсон миний ашигт хуваасан хэмжээтэй тэнцэнэ. Харин миний шудрага үйлдлийн хэмжээ нь бусдад учруулсан хохирлоос надад олдсон ашгийг түүнээс амссан бусдын зовлонгийн хэмжээнд хуваасантай тэнцэнэ" хэмээн А.Шопенгауэр томъёолсон байдаг. Би өөрийн хүсэл зоригийг биелүүлэхийн тулд бусдыг албадан өөртөө хөдөлмөрлүүлж ашиг олох нь шудрага бус явдал гэж тооцогддог бөгөөд ийм шудрага бус явдал нь бусдын дур хүслээр тодорхойлогддог гэсэн санааг гаргасан.

Зөвхөн өөрийн хөдөлмөр хүчийг зориулж олсон ашиг л шудрага явдалд тооцогдоно гэсэн А.Шопенгауэрын гаргалгааг цааш бодож үзэхэд, хүмүүсийн бүх хэрэгцээг ганц хүний хөдөлмөрөөр бүтээхгүй учраас хүмүүс харилцан хамааралтай байх зайлшгүй шаардлага гардаг бөгөөд бусдын хөдөлмөрийг мөлжих нь бас л зайлшгүй болж байгаа юм. Гэхдээ хамтын хөдөлмөр, хөдөлмөрөө хуваарилан эрхлэх үйл ажиллагаанд хэдийгээр бусдаас бага хөдөлмөрлөж ихийг олох сонирхол хүн бүхэнд байх боловч чухам энэ хүсэл бүх хүнд байдаг учраас л хүмүүс харилцан тохиролцож, харилцан хохиролгүйгээр хэргэцээгээ хангах нийгмийн шаардлага, төрийн хууль хэлцлийн шаардлага гардаг юм. Ингэхлээр төрийн хууль журам бол хүмүүсийн хувиа хичээх үзлээс л үүссэн бөгөөд төр улс нь хүмүүсийн хувиа хичээх үзлийг устгах үүрэгтэй бус, харин ч хувиа хичээх явдлыг ухамсартайгаар тодорхой аргазүйгээр боловсруулдаг гэсэн А.Шопенгауэрын үзэл үнэний хувьтай билээ.

Түүнчлэн "Хэн нэгний хязгаарлагдмал хувиа хичээх үзлийг бүх нийтийн түгээмэл хувиа хичээх үзэл болгон тунхагласанд л төрийн үүрэг

оршино" хэмээн тэрээр тодорхойлсон байдаг. Хамгийн оновчтойгоор: "төр улс нь тоо томшгүй тусгаар бие хүмүүсийн хувиа хичээсэн үйлдлүүдийн бусаддаа үзүүлэх хортой үр дагавраас өөрсдийг нь хамгаалах үүрэгтэй" хэмээн А.Шопенгауэр тодорхойлсон юм.

"Төр улс гэдэг бол хүмүүс ганцаараа биш бусадтай хамтарч амьдардаг гэдгээ илэрхийлж, өөрсдөд нь учирч болох тоо томшгүй халдлагуудаас зайлшгүй хамгаалах хэрэгсэл юм" гэж А.Шопенгауэр үзжээ. Хүмүүс харилцан нэг нь нөгөөгөөсөө хамгаалах хэрэгцээ нь "олон улсын харилцааны эрх" гэдгийг бий болгосон гэж тэрээр үзсэн байна. Бүгд шудрага байсан бол хэн ч хэнийг ч гомдоохгүй, хэн ч хэнээс ч хамгаалах шаардлагагүй байх байсан хэмээн тайлбарласан юм.

Тэрээр цааш үзэхдээ, ямар нэг муу үйлийг даран устгахад тэр нь нөгөө муу үйлийг эхлүүлэх боломж өгч байдаг учраас хамгаалагчаас хамгаалах шаардлага, өөрөөр хэлбэл төрийг хамгаалж байгаа хүмүүсээс хамгаалах хэрэгтэй болно. Эндээс "олон нийтийн эрх" гэгч бий болжээ.

Энэ эрхийг иргэний, шүүхийн, гүйцэтгэх гэсэн гурван ангиллаар тус тусад нь өөр өөр хүмүүст хариуцуулбал зохино гээд, гагцхүү төрийн хамгаалах үүрэг нь эдгээрээс өөр зорилго агуулах аваас жинхэнэ зорилгодоо аюул учруулах болно гэжээ.

Хэрвээ төр улс нь өөрийнхөө зорилгодоо бүрэн хүрэх аваас газар сайгүй шударга ёс ноёрхож, хэн ч шудрага бус үйлдэл хийх хүсэлгүй болно. Төр улс байхгүй бол шудрага зүйл хийх нэг ч хүн олдохгүй хэмээн А.Шопенгауэр нэгд, хүмүүс байгаа цагт шудрага бус үйлдэл арилахгүй, хоёрт, шудрага бус үйлдэл байгаа цагт төрийн хууль журам боловсруулах нь дамжиггүй, гуравт, бүх асуудал гэрээ хэлэлцээр, хууль журмаар шийдэгдсэн тохиолдолд шудрага бус үйлдэлд явах газаргүй болно гэсэн харилцан нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлэн тасралтгүй үргэлжлэх нийгмийн харилцааны гурван гол шинжийг тодорхойлжээ.

"Өөрийн мөн чанараараа бусдад зовлон учруулаагүй бол шудрага бус үйлдлийг төр хориглож чадахгүй боловч, энэ нь боломжгүй учраас аливаа шудрага бус үйлдлийг хориглосноор харин ч эсрэгээр, аяндаа урсгалаараа бүх нийтийн амар тайван байдлыг тогтооход чиглэдэг бөгөөд бүгдээрээ ...хүнийг хайрлан сайн үйлийг гүйцэтгэж, иргэн бүр ямар ч идэвхгүй байж, ...ямарваа идэвхт үүрэг хүлээхээс татгалздаг болгоход төр санаа тавих байсан" хэмээн А.Шопенгауэр бичжээ.

"Зэрлэг хүмүүс нэг нь нөгөөгөө барьж иддэг бол, соёлтой хүмүүс нэг нь нөгөөгөө хууран мэхэлдэг... Хууль эрхийн байранд шудрага бус зарчим, хүчирхийллийн ноёрхол тогтох нь үнэндээ байгальд, тэгэхдээ зөвхөн амьтдын ертөнцөд төдийгүй хүмүүсийн дотор ч ноёрхдог хууль мөн бөгөөд үүний хортой үр дагавраас зайлсхийхийн тулд соёл иргэншилт ард түмэн төрийн дэг ёсыг бий болгодог ба энэ дэг ёс алдагдсан ямар ч үе, ямар ч газар оронд тэрхүү байгалийн хууль түүхийн тавцанд дахин гарч ирдэг" гэсэн нь хууль эрхийн ач холбогдлыг тодорхойлсон хэрэг юм.

Ийнхүү шудрага бус үйлдэл нь хүчирхийллээр, эсвэл заль мэхээр илрэнэ гэж А.Шопенгауэр үзжээ. Хүн алахад мэс хэрэглэх үү, хор хэрэглэх үү гэдэг нь эцсийн үр дүндээ ялгаагүй байдагтай адил шудрага бус үйлдлийг ямар аргаар хэрэглэх нь эцсийн дүндээ ялгаагүй хэмээн тэрээр тайлбарлажээ: Хамгийн гол нь шудрага бус үйлдэл хийснээр би бусдыг өөрийнх нь дур хүслээс ангид миний дур хүсэлд захируулж байгаа хэрэг юм.

Хүчирхийллийн арга хэрэглэсэн тохиолдолд би түүнийг өөрийн дур хүсэлд биеэр нь үйлчлүүлнэ, харин заль мэхийн аргаар бол би тодорхой сэдлээр бусдыг өөрсийнх нь дур хүсэлд нийцүүлж байгаа мэт ойлголт төрүүлээд миний дур хүсэлд үйлчлүүлнэ. Энэ тохиолдолд би тэрхүү сэдлийг олохын тулд миний дур хүсэлд нийцэх бусдын дур хүслийг мэдэх хэрэгтэй болно. Гэтэл бусдын дур хүсэл гэдэг нь бүхэлдээ бас л хувиа хичээсэн хууран мэхлэлт байна. Өөрийгөө магтан сайшааж байгаа хэн ч гэсэн өөрийгөө бусдаар хүндлүүлж, өөртөө бусдыг татах, өөртөө бусдыг захируулах далд санаа агуулдаг.

Ийнхүү аливаа заль мэх нь хүчирхийлэлтэй адил өөрийнхөө дур хүсэлд бусдыг захируулах санаа агуулдаг байна гэх мэтээр А.Шопенгауэр тайлбарласан байдаг. Энэ бүх тайлбарт, аливаа үйл ажиллагаа явуулж байгаа хүн өөртөө далд ашиг харж байдаг ч тэрхүү санаагаа ил гаргадаггүй, харин хамтрагчийнхаа олох ашгийг илүү тодорхойлж, түүний тусын тулд тухайн ажлыг гүйцэтгэж байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг гэсэн санаа агуулагдаж байна. Ийнхүү бусдын ашгийг тодорхойлж, өөрийнхөө ашгийг нуудаг ч, ямар ч гэсэн бусдын ашиг сонирхлыг тооцох зайлшгүй шаардлага гардаг нь гэрээ хэлэлцээр, хууль журмын үндэс болдог байна.

Хүмүүсийн хооронд байгуулагдсан гэрээ хэлцлийг зөрчих нь жинхэнэ заль мэх болдог гэж А.Шопенгауэр үзжээ. Учир нь гэрээ хэлцэлд хоёр тал хоёулангийн сэдлүүдийг, аль алиных нь дур хүслийг харгалзан томъёолдог. Чухам үүнд л нийгмийн гэрээ хэлцэл буюу төрийн хууль ёсны үүргийн ач холбогдол оршино. Гэрээнд заасан үүргээ эс биелүүлэх нь хүчирхийлэл, шудрага бус явдлыг төрүүлэх гол нөхцөл болдог гэж тэрээр тайлбарласан. "Бусдын эрхийг зөрчихтэй холбоогүй шудрага бус үйлдэл гэж байдаг бол төр нь түүнийг хориглохгүй байх байсан" гэж А.Шопенгауэр бичжээ.

А.Шопенгауэр хууль журам ба ёс суртахууны ялгааг тодорхойлж: "Ёс суртахууны ...цорын ганц бодит агуулга нь дур хүсэл ба бодол санаа мөн бөгөөд түүнийг зөвхөн жинхнээрээ биелсэн худал хуурмагтай бүрэн тэнцэх тийм гадаад хүч л зогсоож мөлждөг ба ёс суртахууны шүүхийн өмнө ийм хүсэлтэй хүн л гэмтэн гэж тооцогдоно. Харин төр нь үүний эсрэг, дур хүсэл, түүнтэй холбоотой бодол санааг ерөөсөө сонирхдоггүй, түүний хувьд үйлдэл нь л чухал" гэжээ. А.Шопенгауэрын иймэрхүү үзэл Европынхны дунд хөгжсөнөөр хууль журмыг ёс суртахууны сургаалаас ялгаагүй байхаар боловсронгуй болгож иржээ.

Төр нь хүмүүс юу бодож байгааг сонирхохоосоо илүү юу хийж байна гэдгийг анхаарч хянаж байдаг гэж А.Шопенгауэр тодорхойлсон байдаг бөгөөд түүний үеэс хойш европын орнуудын хуульзүйд хийсэн бодит үйлдлээс. Гадна санаа сэдлийн чанартай зүйлсийг ч хуулинд тусгах болсон юм. Ийнхүү ард түмний хүслийн илэрхийлэл болсон философичдын үзэл санаа нь эргээд нийгмийн хөгжилд нөлөөлдөг ажээ. Төрийн өмнө хүмүүс алдаа гаргаж, буруу зүйл хийх эрхгүй байдаг, чухам үүнд л төрийн хууль эрх зориулагдана хэмээн А.Шопенгауэр тайлбарласан.

А.Шопенгауэрын үзлээр хууль эрх болон хуулийн тухай сургаал нь үнэндээ урвуулсан ёс суртахуун мөн:

"Хууль зүй нь эрхийн тухай буюу зөв буруугийн хил зааг, утга учирын тухай сургаалаа ёс суртахуунаас авахдаа түүний урвуу шинжийг түүнээс өөр ёс суртахууны зорилгод ашиглаж, үүнд тохирсон эерэг хууль, түүнийг хадгалан барих арга буюу төрийг тогтоодог. Ийнхүү эерэг хууль зүй нь дээр

өгүүлснээр цэвэр ёс суртахууны урвуу сургаал юм. Тодорхой ард түмэн өөрийн онцлог харилцаа нөхцөл байдалдаа тохируулан үүнийг хэрэглэдэг. Эерэг хууль нь бүхий л мөн чанараараа зөвхөн цэвэр эрхийн тухай сургаалын заалтуудаар тодорхойлогдсон тохиолдолд л тухайн тогтоосон хуульзүй нь эерэг хууль байж, тийм төр нь ёс суртахуунгүй байгууллага биш, харин бүрэн эрхт холбоо, жинхэнэ утгаараа ёс суртахуунаар зөвшөөрөгдсөн төр байж чадна. Эсрэг тохиолдолд эерэг хуульзүй нь эерэг буруу байгууллага болж аяндаа албан ёсоор зөвшөөрөгдсөн хүчирхийллийн буруу шинжтэй болно."

Ийнхүү аливаа хэрэглээний шинжлэх ухааны үндсэнд математик байдагтай адил хэдийгээр урвуулсан байдлаар боловч ямар ч хууль зүйн үндсэнд ёс суртахуун байдаг гэж А.Шопенгауэр үзсэн. Ингээд эрхийн тухай цэвэр онол сургаал нь философийн онолтой адил дараахь зорилгуудыг агуулна хэмээн тодорхойлжээ. Үүнд :

1. Зөв ба буруу гэсэн ойлголтуудын дотоод мөн чанар, гарал үүсэл, тэдгээрийг ёс суртахуунд хэрхэн хэрэглэдэг болохыг тайлбарлах,
2. өмчийн эрхийг боловсруулах,
3. төрийн хэлэлцээрүүдийн ёс суртахууны үндэс болгож хэлэлцээрүүдийн ёс суртахууны хүчин чадлыг тогтоох,
4. төрийн үүсэл ба зорилгыг тайлбарлаж, тэдгээр зорилго нь ямар ёс суртахууны агуулгатай болох, тэр нь ямар ач холбогдолтойг тогтоох замаар хууль зүйд эрхийн ёсзүйн сургаалыг үндэслэлтэйгээр хэрэглэх,
5. шүүн таслах хууль эрхийг боловсруулах эдгээр болно.

Гэвч бүхэлдээ А.Шопенгауэрын хууль эрхийн болон ёсзүйн тухай сургаалдаа дэвшүүлсэн төрийн үүрэг зорилгууд хөгжингүй бус орнуудын бодит байдалд тэр бүр хэрэгждэггүй бөгөөд иймээс ч шудрага бус үйлдэл, хүчирхийлэл, заль мэх, нийгмийн харилцааны зөрчил гүнзгийрэх шинжтэй байдаг. Хууль журам, гэрээ хэлцлийг хэдий ёс суртахуунлаг, хүнлэг, хүн ёсны ариун дээд чанарт нийцүүлэн боловсруулна, төдий чинээгээр нийгмийн хямрал зөрчил, заль мэх, худал хуурмаг, шудрага бус зүйл хязгаарлагдана.

Ашигласан материал:

1. Избранные произведения. М. 1992.
2. Шопенгауэр Артур. Свобода воли и нравственность. М. 1992.